

Үйл үйлдлээр аргадах засалд

Ч. Болдбаатар, Т. Цэцэгжаргал

Эртний шүтлэг-зан үйлийн синкретик тогтолцоо бүхий “аморф” хэлбэршлээс улбаалсан биеэр үйлдэгдэх өвөрмөц дохио зангалбар эдүгээ тайзны урлагийн хэллэгт ойртон ухагдах боллоо. Нэг ёсондоо дохио нь утгашиж, хөдөлгөөн нь галбирших маяг төрхөд шилжсэн гэсэн үг юм.

Судлаачид тэрхүү үйл хөдлөлийн үүтгэлд чимээ хийгээд зурлагын аймаглал үгүй мөртөө “бибинар” олшруулалт тайгддагийг нэлээдгүй судалж, зарим таамгийг дэвшүүлсэн нь сонирхолтой байна. Тухайлбал, Германы эрдэмтэн Хайссиг өөрийн бүтээлдээ¹³¹ номхотгон засах үйл нь ардын харын шүтлэгийн олон зүйлстэй сүлэлдсэн тухай тэмдэглээд, тэдгээрийн цаашид хэрхэн хувьсаж өөрчлөгдсөнийг сайтар шинжихэд биеэр үйлдэгдэх занга дохиог судлахгүйгээр огтхон ч хийгдэх боломжгүйг анхааруулжээ. Номхотгон дарах үйлээ дагаад хариулга нь өөр өөрөөр боловсроход хүрсэн төдийгүй нүүдэлчдийн орон ахуйн нөхцөлтэй уялдаж, үйлдэл мөрөө гаргах дохиогоо машид нууцладаг нь ч судлууштай зүйл. Бид өмнөх судалгаандаа¹³² биелэгийн үүсэл гарвалыг баларлиг нийгмийн харилцаан дахь хамтын ухамсаргүйн талаас буюу дом, шившлэг, дэвсэлгийн хүрээнд тайлахыг оролдсон бол энэ удаад зөвхөн бий биелэг төдий бус харин заслын арга чарга болох талаас нь хөндөн нягтлалаа.

Байгалийн сүр хүч тэргүүтэн лус савдгийг аргадах зайлал нь дан дан бие даасан сахиус болон тэдгээрийн нөхөр бологчийг эрхэмлэсэн үйл үйлдлийн оронг заагаад зогсохгүй энгийн засал маягтай зүйл рүү хялбаршиж шилжсэн бололтой байна. Ялангуяа өвчин зовлонгийн хариулгын тухайд элдэв эрхэс, нар гэх мэт эгэлгүй хүчийг өөр өөрсдийн чинээнд амьтанлаг төрхөөр хэтийдэн бэлгэдэж, түүнийгээ ёр билгийн хүчээр дамжуулан ойлгодог тал нь бүр ч сонирхууштай байдаг. Энэ бүхний угт үйлд тохирсон гар, хөлийн хөдөлгөөн, дэвсэлгийн тухай ярих хэрэгтэй болно. Биеийн ая байдлаас үүтгэн гарзын үүдийг хаах, авлагын үүдийг нээж чадваас үлэмж тустай хийгээд аливаа байдал дүрд орших, золигийг хад чулуунд тээх (зурлага дом), улмаар чимээ оруулан хэц тээг цохих, дэлдэх, авиа хүч харшуулахгүй нэгэн мөр биеэр үйлдэх тал ч чухал. Нэрт судлаач Л. Хүрэлбаатарын өгүүлсэнчлэн “...биеийн дүр байдлыг ганхлан сэгсрэх тэргүүтэн мутрын хөдөлгөөнд мэргэших...хэлээр шившлэгийг урихуйд үл тасалдах ба сэтгэлээр далд хүчний аль алины омгийг бат барих...хэрэгтэй”¹³³ хэмээсэнтэй утга дүйх ажгуу. Үүний нөгөө сацуу хөдөлгөөн горьг нэгэн хүлэлд барьж хашиж болохгүй, тухай

¹³¹ Heissig W. *The religions of Mongolia*. London and Henry. 1980, p 816.

¹³² Болдбаатар Ч нар. *Ариун дагшин сэтэр (дохиолбор) амбивалент шинжид холбогдох нь* // АСТА Mongolia, Vol 14 (400), УБ., 2014, х 17-24.

¹³³ Хүрэлбаатар Л. *Монгол цам* // Олон улсын монголч эрдэмтдийн YI их хуралд тавьсан илтгэл (хэвлэлд), УБ., 1992, х 3.

тухайн орон ахуйн эрхээр төлжих ёстойг шүтээн номын үүднээс тодорхойлсныг үлэмж барьж таниуштай. Үүнд Агваанлуvsанхайдавын “*Шашны сахиулсан далайн бүжиг цамыг гийгүүлэгч тангарагтны зүрхний толь*” сударт өгүүлсэнчлэн гарын байдлыг эрхэмлэснийг “*бүжиг*”, хөлийн байдлыг эрхэмлэснийг “*дэвсэг*”, тус хоёулыг хамтад нь эрхэмлэснийг “*ая байдал*” хэмээснээс үйлийн лайг биеэр хэтийдэн зайлуулахад харшлах зүйл эс буйг мэдэж болох мэт. Хөдөлгөөний хэм давталтыг дурдваас, [таван таслалын хөдөлгөөн], [долоон хөлтний таслал хөдөлгөөн], [ашидыг дэлгэрэх хөдөлгөөн], [хилэнцийг дарах хөдөлгөөн] гэх лугаа тус бүр тохирсон үүрэг хэлцэлтэй боловч угтаа галыг цөм болгон хэсэг бүлгээрээ тойрон дэвсдэг явдал өдгөө хүртэл хадгалагдаж ирсэнийг мөшгөх шаардлагатай байна.

Уул усны эзний хүнчилсэн дүр (догшид) шинжийг дом заслын үйлдэлтэй жишсэн судалгааг Н. Л. Жуковскаягийн ажлаас¹³⁴ илүүтэй харж болно. Гэхдээ шашны агуулгатай зан үйлийн шинжтэй ёслол үйлдлүүд нь нөгөө талаар соёл сэтгэц зүйн бүтэцтэй холбогдож байж мэднэ. Үүнийг ч А. М. Позднеев¹³⁵ нууц тарнийн шившлэг нь ер бус чанараараа ижил авч өргөлийн эзэн болоод барьц, золиг гаргах цээрээрээ ялгагддаг гэсэн нь үнэхээр онож хэлсэн үг. Хувилбаржсан уг санааг А. Д. Авдеев¹³⁶ дэмжиж “*дэвсэг нь маш олон хэсгээс бүрэлдсэн, тэр нь үйлийн олон янз арга чаргыг бий болгосныг бас давхар нотолж байгаа юм*” хэмээжээ. Энэ бол бидний эрж байгаа зүйл мөн.

Нэгэн зүйл- хий хөдөлгөөнөөр домнох ховс.

Нүүдэлчдийн дунд эртнээс нааш “*тэнгэр хаясан*” буюу “*аз харьсан*” гэх төөрөг заяаны тухай ойлголт ам амнаас дамжиж, үйлээс үйлдэлд хөтлөгдөж иржээ. Үүнд чухамдаа үйлийн явдал суудал, зам мөрийг засах гэтэлгэлт өгөгддөг тал буй. Энэ нь аз зэтгэрээс түр боловч ангижрахыг дохиох зөн хувьтай билээ. Тухайлбал, бөө мөргөлийн тамлагад хүний сүлд зайлбал бүсийг нь тайлан, хэт цахиурыг цахиж бөөлөхүйд сүлд эргэдэг гэх. Түүнчлэн үйлийн хэмнэл-хөдөлгөөний хамтаар аргалж чаргалж байсны нэгэн тодорхой баримт нь “*Андай дэвсэг*”¹³⁷ засал-дом байхыг бид ихэд сонирхож үзлээ. Галаар ариусгахын нэгэн хувилбар болох андай дэвсэг өдгөө цагт уламжлагдахдаа залуу бүсгүйн биед шүглэсэн муу ёрыг үлдэн зайлуулахад бултаараа хамтран удган залж, төөрсөн заяаг эргүүлж авчрах үйлийг урин дуудлагаас улбаатай юм. Эгэлгүй тэр хүчийг хөдлөл биелбэрээр зайлуулан засаж, “*нөгөө зүйл*”-ийг гэтэлгэн шүглэлийг хөөх буюу бүлээрээ гороолон галын зүсийг ажиглаж хариулдаг нь бас л мартагдсан зүйл. Иймэрхүү дом ховсын үлдэц нь галын сүнстэй харьцах, мөнөөхийг аргадах, урин дуудах, хуурах зэрэгт агуулагддаг. Удган бөөгийн засал чаргад “*орлуулж үйлдэх*” хэмээхүй нь мөн чанартаа галын эзний дохио зангыг дуулгавартай дагахын үйл бөгөөд тэр нь нэгийг нөгөөгөөр золихын угтал байдгийг бид мэднэ. Дэвсэлгэ үйлдэн, газрын эрчмийг биед шилжүүлэн хүч орох зан ахуй төсөөлөл¹³⁸ олон газар усанд тээгдэж, биелэг зангаар

¹³⁴ Жуковская Н.Л. *Ламаизм и ранние формы религий*. М., 1977.

¹³⁵ Позднеев А.М. *Очерки быта буддийских монастырей и буддийского духовенства в Монголии в связи с отношением сего последнего к народу*. //Записки Русского Географического общества по отделению этнографий, т. XVI. СПб., 1887, с 392

¹³⁶ Авдеев А.Д. *Происхождение театра*. Л.-М., 1959, с 174.

¹³⁷ Андай бүжиг-Хүрээ хошууны болон Монголжины овог аймгийн дунд байдаг, бага залуу эмсийн өвчнийг засах дом.

¹³⁸ Монголын нууц товчооны 57-р зүйлд “...Хутулыг хан өргөөд, Хорхонагийн саглагар мод тойрон орчиж, хавиргандаа хуулга болтол, өвдгөндөө өлхөг болтол дэвсэв” гэжээ. (*Монголын нууц товчоон*, УБ., 2006 он, 27-р тал). Энэ нь “гадаад талын дүр дүрслэл” гэхээсээ илүүтэй бүжиг нь “уд” мод (шүтээн, гал)-ыг тайх

тархсаны нэгэн баримт нь Ордос, Хорчин монголчуудын “Уд мод” буюу “Шани мод” (хэц мод)-ыг тахих ёслол бөлгөө. Уг ёслолын тухайд зарим судлаачид тэмдэглэхдээ “...овог аймгаараа цуглараад “Шани өвгөн”-ний ам хамрыг шар тос, өөхөөр мялааж, тойрон сөгдөн сууж, арц хүж унгасгаж, наминчлан хувь хувийн хүсэлтээ шивнэн даатгасны хойно хөгшин залуу, эр эм бүгдээрээ сүүн цацал өргөн, шани модоо тойрон дуулж бүждэг¹³⁹ хэмээсэн байна. Зарим тохиолдолд тэрхүү тайлгыг нар шингэж, сар дээр мандтал үйлдээд, шани модны эзэн савдгийг баясгаж, ивээлийг даах, хүссэн үйл ёсоор болохыг нууцхан айлддаг нь нөгөөх л далд хүчний ойлголтыг илтгэнэ. Тэр тусмаа тойрон биелж, дуу чимээ өргөхийн ерөөлөөр элэнц хуланцтайгаа харьцах, тэдний аяг занг давхар аргадан засахын сацуу нэгд, бүлээрээ үйлдэх, хоёрт хөдөлгөөний эрчмийг аажмаар хурдасгах, гуравт, хэдий чинээ өнө удаан үйлдэнэ төдий чинээ өршөөл энэрлийг хүртэх нь лавтай гэх бишрэлийг төрүүлдэгийг бас анхаарах нь зүйтэй.

Аливаа үйлдэл хөдөлгөөн бүр биеийн галбиршил хэмнэлээр дамжин тодорхой ая байдал үүсгэдэг учраас учирсан гай тотгорыг зайлуулан цаашдын зам мөрийг тэгшитгэхэд түүний нөлөөллийн “ид”-д итгэх явдал газар сайгүй байсныг тэмдэглэмээр. Энэ утгаараа “засал ховсог” бол нэг талаас биеийг ариулан сүсэхээс улбаатай сэтгэлийн “өргөл”, бишрэл төрүүлэх “аврагч” байж, нөгөө талаас зөн, хүсэл, бишрэл гурвын харилцан уягдах биелбэр дохио болдог аж. Өнөө хэр нь сэтгэл зүйн эмчилгээний арга засалд удганы дуудлагатай хамсрах биелбэрийн хэлбэр¹⁴⁰-ийг ашиглаж байгаа нь ч дээрхийг санагдуулам юм.

Энд “Сацал”, “Мөргөл” хэмээдэг биелэгийн зан үйлийг дурдах хэрэгтэй болно. Дөрвөд, Баяд, Урианхай, Хотон гээд ястан бүрийн бий-биелэг нь хэдийгээр хөдөлгөөний хувилал дэгээрээ ялгамжтай боловч урьдын ёс үйлийн ул мөрийг илтгэх түгээмэл дохио занга бас бий. Тухайлбал, “Мөргөл бий” гэхэд уул усны эзэн сахиус, элэнц хуланцын сүнсээ амар байлгах, ивээлийг хүсэх үйл мөрийн ая, хий тэмдэг байхад, “Сацал бий”-д гарын алга дандаа дээш харж байх нь хангай дэлхийдээ сүүн сацал өргөж, сайн сайхныг (хур бороо дуудах) урин дуудахын дохио байдаг байна. Ийм сацал биелэг байгалиа төдийгүй овог бүлгийн сүр сүлдээ тайхаас эхтэй бөгөөд дөрвөн тал, найман зовхистоо шившиж заншжээ. Жишээлбэл, торгуудын “Сацал” биелэгт мөрөө зөрүүлэн хаялж, хөлийг солбиж гишгэх, хоёр гарын алгыг дотогш хумиж гадагш сацах хөдөлгөөн голлодог нь ч үүний ул мөр бөгөөд гар хөлөө зөрүүлж хөдөлгөдөгт ч магад утга өгүүлэгдэнэ. Ардын билиг зүйч Ж. Бадраа гарын гадагш, дотогш царвах хөдөлгөөнийг хүннү нараас гаралтай “биба” хөгжмийн нэртэй холбон тайлбарлахдаа “Би” гэдэг нь бие, “Ба” гэдэг нь газар утгатай бөгөөд би нь гар биеэсээ гадагш, ба нь газраас бие рүү хөдлөхийг заана¹⁴¹ гэсэн нь ч бидний сонирхож буй сэдэвт магад холбогдох сонирхолтой баримт юм. Биелэгийн дэгт гарын сацлага голлохын зэрэгцээ бугуйн хаялага нь ямагт дотроос гадагш чиглэх нь хөдөлгөөний эргэлэгийн “бас, бус”-ын дохио байж мэдэх юм. Хөдөлгөөнөөр биеийг засан аргахад амьсгал авах, гаргах хийн урсгал

буюу уул усны эзнээ урин дуудах, аргадан хөгжөөх, тэр тусмаа бүлээрээ үйлдэхийн учир холбогдолтой зан үйлийн нэг улбаа мөнийг магадлана. Ийм бүжгийг хожим нь Зүүн болон Төв халхын бүжиг болон өнөөгийн буриад зоны ёхор, егхэр уламжлагдсан гэж судлаачид таамагладаг.

¹³⁹ Монгол ёс заншил, зан үйлийн товчоон, УБ., 2009, х 535.

¹⁴⁰ Грекийн Пиццика бүжиг-Эмэгтэйчүүдийн хүч чадлыг сэргээх, сэтгэл санааг эмчлэх зорилгоор хэнгэрэгийн аяар дуулан бүжиглэдэг.

¹⁴¹ Биба-нэгэн зүйлийн чавхдаст хөгжмийн зэмсэг, Хүннүгийн үед монгол түмний дунд тархмал байсан. (Бадраа Ж. Монгол ардын хөгжим, УБ., 1998, х 89)

чухалтайг, цаашлаад байршил чигийг мэдрэх тутам биеэр хэмнэлийг илэрхийлэх боломжтойг тэмдэглэмээр. Савдгийн орон хийгээд лүн хугацалыг “эрхэсийн”, “нарны”, “сарны” цаглабараар ангилж ялгадаг нь хөдөлгөөний [эргэлэг-байршил]-тай тохирдог тал бий. Хүн залбирал мөргөлөө ёсочлон үйлдэх болсноос хойш биеийн эд мөчөөр тайлга тахил өргөж, хэмнэл эргэлгийн таарах таарахгүйг дохион хэрэглэсэн нь зөвхөн зан үйлийн утгаар хязгаарлагдахгүй, харин бүжих алогик сэтгэмжийн үүдэлтэй холбогдохыг дахин тэмдэглэмээр байна.

Нэгэн зүйл-наадаанаар засах дом шившлэг

Монгол овог аймгуудын дунд шүтлэг мөргөлөө биеэр үйлдэж тайх арга чаргын ул мөрийг наадаан-тоглолын хэлбэрт хадгалан уламжилсан тухай баримт нэлээд байдаг. Тухайлбал, “тэмээцэх”, “цагаан мод хаях”, “чоно тарвагацах” гэх мэт. Тоглоом бүр хөдлөл хөдөлгөөнтэй нэгдмэл задалж хэлбэл, хөдөлгөөнт тоглоом (перформанс) бий бийлэг хоёр синкретик шинжээр холбогдсоныг үгүйсгэх аргагүй. Ийм дуу чимээ-хөдөлгөөний хавсарга үйл үйлдэл нь мал ахуйгаа мэнд амар байлгах ерөндөгтэй сүлэлдэх ба сүрэг тарган, сааль сүү элбэг, чоно нохойгүй, өвчин эмгэггүй, ургац шим ихтэй байхын домьг илтгэнэ. Уул наадаан бүр язгуураараа ховс чатгын эртний гарвал оршиж байхыг магадлахын зэрэгцээ үйлдлээр үйлийг засах хам шинжтэй хосолсоныг харуулдаг. Ийнхүү чимээний дуудлага, хөдлөлийн хүч, домьн хариулга, дамжуулалт бүгд өөр хоорондоо нөхөгдөж, синкретик оршдогийн зэрэгцээ наадаанд хуурч аргадах мэх мэхлэл чухал үүрэгтэй билээ. Бидний үзсэнээр бол юмыг золино гэдэгт нэг талаас адилтгахын (төлөөлүүлэх), нөгөө талаас хэрэглэхийн (үйлдүүлэх) хувь байгааг бодолцох ёстой. Наадгайн хөдөлгөөнт бүтэц нь тэмдгийн тогтолцоог загварчлан тодорхой тодорхой үйлийн оролцоог хөгжөөх галбиршлын элементүүдийг агуулдагаараа онцлог. Учир нь, наадгай бүр домогзүйн төсөөлөл агуулдаг төдийгүй бинарчлах үзэгдэл мөн. Хоёрдмол эсрэгцэл наадгайд байдаггүй. Яагаад гэвэл, бинарчлах тогтол жаяг нь “зэрэгцэл” юм. Тэгээд ч “байх” ба “байхгүй” нь дан дангаар (салангидаар) биш, чухамхүү “дайсан” нь “нөхөр” байхуйц өгөгддөгөөрөө онцлог. Хариулга хийх ховс жатга мэтийн хүнээс хэтийдэх оломгүй тээг нь ганцхан бие махбодын хэрэгцээгээр хязгаарлагдахгүй, тэдгээрийн чанадад үл хүртэгдэх ертөнцөд хандах мэдээллийн түлхүүр болдгийг ойлговол зохино.

Иймэрхүү ховс занга нүүдэлчдийн ёс заншлаас үлэмж хэмжээгээр харагддаг. Байгалийн эзэн биегүй юмс үзэгдлийг амьдчилж аргадана гэдэг нь алга хавсран таших дуу чимээний хүч шиг хөдөлгөөн сүрийг тайх үйлдэл дохионы шид байж, урьдаас шарх оноон гэтэлгэхтэй адил дом зангын хэлмэрт хамаатай зүйл юм. Улмаар малыг гаршуулах явцад хонийг тойглох, ямааг гүүглэх, ингийг хөөслөх, гүүг гурайлах зэргээс гадна тагнай таших, уруул товших, исгэрэх мэтийн зан үйлийн аялгуулал болж хувирсан гэх баримт нэлээд байдаг. Тухайлбал, тагнай таших нь гаслан зовлон учрахын, уруул товших нь хүйтэрхийн, исгэрээ нь сэрүү татахын тэмдэг зөн болж ойлгогдоно. Буриадад ан авын эзэн, сахиус савдагт зориулан онгоныг баясгах үйлийг “Ягшаа хатир” гэж нэрлэдэг гэх. Зарим судлаачид үүнийг XIII зууны үед монголчуудын дунд байсан “Ягшаа наадаан”¹⁴²-аас үүдэлтэй хэмээжээ. Уг ёслолд ус хангайн эздийг баясган аргадаж, байгалийн ивээлийг хүсэмжлэн үдшийн цагаар түүдэг гал эсвэл саглагар мод тойрон гар гараасаа барилцан дуулан дэвсдэг нь эдүгээ заншжээ. Үүнийг ураг тариг барилдах наадаан буюу

¹⁴² “Ягш”-тахил өгөгч, тэнгэр нарын тахил үйлдэгч, (Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, х3248)

“Басганы их наадаан”-наас харж болно. Буриадын заншилд буй “Басганы их наадаан” нь гэрлэх зан үйл хийгээд дуут бүжиг, наадааны цогц болохынхоо хувьд “...орон дэлхийн эзэд, овоо уулын савдаг, ус лусын эзэд, онгод тэнгэр нар хотлоор баясаж, хоймрын хор, хотны тоггорыг тонилгож, залуусын хийморь цог золбоог бадраадаг”¹⁴³ тул ийн үйлддэг аж.

Наадан өрсөх, нөхөрлөж айлсах гэдэг хүмүүнд заяагдмал зан авирыг илтгэх шинж бөгөөд хүн төрөлхтнөөс боловсруулсан “хориг-тоглоом” юм. Нүүдэлчид нөхөрлөж айлсаад андын журам сахидаг ёсоо тоглоом наадгайн хүрээ рүү оруулж, түүгээр дамжаад хүний үйлийн дотоод түлхэц-энерги эрчмийг засаж болдогийг ухаарсан нь дурьдсан баримтаас илт байна. Үйлийн тэмдэг (наадаан) нь юуны өмнө сэтгэлзүйн бүрэлдэхүүн хэсэг болох ухамсаргүйн эхлэл гэж К. Юнг үздэг. Зан авирын хэлбэршсэн дүр төрхүүд заяамал төдийгүй тоглох хүсэл давтагдмал өгөгддөгөөрөө “архетип” тэмдэгт болж хүмүүст аяндаа үйлчилдэгийг тогтоожээ. Тодорхой хэлбэл, архетиплиг сэдлүүд (сүт зурлага, шившлэг тамлага, дэвсэг наадаан...) хүний оюун ухаан дахь элэнц хуланцын санагалзал, удамшиж ирсэн зан авир (сэтгэлзүйн), далд ул мөрүүдээс эхтэй гэсэн үг. Тэгээд ч хүн бусдаас ангид байж чаддаггүйтэйгээ адил түүний сэтгэлзүйн амьдралд үргэлж “мөнөөх” буюу “эс үзсэн нэг юм” гэх өөртэйгээ төстэйг эрдэг зан тээгддэг. Ижлээ хайх сэрэмж зуршлыг З. Фройд “би” ба “мөнөөх” хоёрын хооронд зуучилдаг хүний дур хүсэлтэй холбож ярьдаг. Гэхдээ “супер эго” нь нийгмийн утгаар хэрэглэгдсэн томъёолол. Эндээс бид, хүний эрх дураар наадах гэдэг ерөөс био энергийн хуримтлалтай эн тэнцүү байх нийгэмших дур хүслээр нөхөгддөг гэсэн гаргалгад ойртоод ирлээ. Яагаад гэвэл, наадаан бол айдсыг дарах ерөндөг мөн.

Хүний сэтгэцлиг амьдралын гол сэдэл бол байнгын айдас буюу түгшүүрт мэдрэмж, тайван бус байдал. Үүнээс хүн дайжихыг үргэлж хүсдэг. Эдгээр цочрол нь хувь хүний төдийгүй хамтын ухамсар бусын (зан авир) суурь болж дагалддаг гэж Фройдыг залгамжлагч Керен Хорин тэмдэглэдэг нь бидний судалгаанд тун чухал үндэслэгээ байв. Нөгөө талаар мэдрэмжлэг зүйл бол “дорд” (муу зүйл) байдал, харин аскетик хэтийдэлт бол “ариун дагшин” (гэгээлэг зүйл) хэмээн ойлгодог дорно дахины баримтлалыг эргэн санах хэрэгтэй болов уу. Уг ойлголтуудаас “мөнөөх”-ийн хүч чадал шилжиж байршдаг тухай метемпсихозын үзэл бүрэлдсэн бөгөөд ариун сүнс бусад хүмүүст, амьтан ургамалд байршаад зогсохгүй эрдэс чулуулигт хүртэл дамждаг гэх төсөөлөл нүүдэлчдийн соёлд, ялангуяа хадны сүгийн зүйлд шууд илэрдэг. Иймээс л “дахин төрөл” олуулахын тулд биеэр тайлга дэвсэг үйлдэх (өргөх) дом зурлага, ер бус чимээтэй хамтдаа ухагддаг. Эдгээр зан үйлийг буюу онгон дагшин савдагт даатгах, түүнчлэн хадан гэртээ заларсан өтгөстэй зөвлөлдөхийг уул усны эзэн мэднэ гэж төсөөлдөг байж. Гэхдээ бие хэдэнтээ “дахин төрөх” гэх шууд утга энд яригддаггүй. Гагцхүү ёс болгох нийтлэг шинжийн хувьд хүний оюун санааны урсгал (мэдээлэл) өтгөсийн үеэс хамаатан оршдог гэх санааг илтгэдэг байх юм.

Эцэст тэмдэглэхэд, [дом-шившлэг], [ховс занга] хосолсон “засал-шидийн” [бода-биеэр] тайх үйл нь амьдралд нөлөөлөөд зогсохгүй хамгийн эрхэм зүйл байсан байна. Үүнд үйлийг эрхшээхүй нь [орон-мэнгэ], эрхэсийн [байрлал-солбилцол], савдагийн догширох [гүйдэл-суудал] гэх зэрэг явдлаас шалтгаалдагийг мартаж болохгүй. Тухайлбал, уул усны эзэн-савдаг тантрын номонд баруун мутартаа ад зэтгэрийн хорлолыг гэтэлгэх аршаан (хор) бүхий алтан бумба, зүүндээ чөтгөрийн санааг үлдэн хөөх

¹⁴³ Гантогтох Г. “Монгол зан үйлийн аман яруу найргийн уламжлал”, УБ., 2007, х 69.

шидэт саваа (алтан мөчир) барьснаар дүрслэгдэх жишээтэй. Савдгийн орон гэр нь тус тусын шинжийг агуулдаг төдийгүй гүйдлийн мөр тус тус ялгагддагийг судлаач К. М. Герасимова авхай нэг бүрчлэн тэмдэглэсэн тул зарим нэгийг эш болгон оруулав.¹⁴⁴ Энэ бүхнээс үзэхэд, хүн төрөлхтөнд нийтлэг ухагддаг ад зэтгэрээс дайжих арга ухаан, засал ерөндөгийн айг ухахын тулд зөвхөн түүхээс алслагдсан ул мөр лүү өнгийх биш, хэт хожмын бүжиг, бүжиглэлийн мистик сэдлийн гүнд зорчих ёстой болох нь.

SUMMARY

The exorcism by action and movement

To sum up, the action “exorcism-magic remedy”, which is the combination of mantra-magic cure and hypnosis, not only influenced on the life but also was the most precious thing. The domination of actions depends on [realm-spot], heavenly bodies [ordination-coordinates] and enraging deities which should not be forgotten. For instance, it is described in the book of Tantric deities as holding a golden jug with (poison) on his right hand to exorcise a demon’s evil and a magic stick (golden bough) on his left hand to chase a demon’s spirit. Scholar Gerasimova, K. M. , has studied the peculiarities of each deity’s realm in detail and some of them have been taken as an example here.

Analyzing all the above mentioned, the study of exorcism and magic remedy ought to be investigated not only from the trace of history but in the depth of the mystic expression of a dance.

НОМЗҮЙ

1. Авдеев А. Д. *Происхождение театра*. Л. -М. , 1959.
2. Бадраа Ж. *Монгол ардын хөгжим*, УБ. , 1998.
3. Болдбаатар Ч нар. *Ариун дагийн сэтэр (дохиолбор) амбивалент шинжид холбогдох нь* //АСТА Mongolia, Vol 14 (400), УБ. , 2014.
4. Гантогтох Г. “Монгол зан үйлийн аман яруу найргийн уламжлал”, УБ. , 2007.
5. Герасимова К. М –“Обряды астрологической магии” //Культура центральный Азий: письменные источники. У-Ү. , 1999.
6. Жуковская Н. Л. *Ламаизм и ранние формы религий*. М. , 1977.
7. Heissig W. *The religions of Mongolia*. London and Henry, 1980.
8. *Монголын нууц товчоон*, УБ. , 2006 он.
9. *Монгол ёс заншил, зан үйлийн товчоон*, УБ. , 2009.
10. *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь* //ШУА, УБ. , 2008.
11. Хүрэлбаатар Л. *Монгол цам* //Олон улсын монголч эрдэмтдийн YI их хуралд тавьсан илтгэл (хэвлэлд), УБ. , 1992.

¹⁴⁴Герасимова К.М –“Обряды астрологической магии” хэмээх одон зурхайн тайлбарт: Востока-материк Пурба Видеха махараджа белын Дхритараштара их гандхарвы (дися), [знакбарха]- “син”, [знак мэба]- “четыре зеленых”, годы 12 летного цикла- “тигр и заяц”, элемент “дерево”... (Культура центральный Азий: письменные источники. У-Ү. , 1999, с.29) гэжээ. Мөн гүйдлийн (догширох) цаг хормыг өдрийн хувьд “жин үд”, шөнийн хувьд “шөнө дунд” гүйхээр, түүнчлэн гүйх чигийг дорноос хаялахыг тэмдэглэсэн байна.

12. Позднеев А. М. *Очерки быта буддийских монастырей и буддийского духовенства в Монголии в связи с отношением сего последнего к народу.* // Записки Русского Географического общества по отделению этнографий, т. XVI. СПб. , 1887.